

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-12
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	13-41
1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал	2-8
2.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	8-30
3.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, О.Цогтгэрэл, А.Ариунзаяа, Б.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа нарын өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг/	30-38
4.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргыг сонгох тухай	38-41

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 07 дугаар сарын 04-ний өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 05 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Л.Оюун-Эрдэнэ, Н.Номтойбаяр, Н.Учрал, Л.Гантөмөр, Э.Одбаяр, Ц.Туваан.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын Байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д “Энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ.” гэж заасны дагуу өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулав.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Монгол Улсын Засгийн газраас 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийтийн өмчийн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон дагалдах бусад хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	4
Бүгд:	14

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 10 цаг 13 минутад хэлэлцэж дууслаа.

Хоёр.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх И.Баттөгс нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын Байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Байгаль орчин, хүнс, хөдөө ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа нар тус тус танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн тавьсан асуултад Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат хариулж, тайлбар хийв.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Төслийн “**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 3
Бүгд: 16
81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир: 2.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“**3 дугаар зүйл.**”¹ дүгээр зүйлийн 7¹.2.1 дэх заалтыг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 3
Бүгд: 16
81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дагалдан гарсан:

Хоёр.Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дөрөв.Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, М.Ганхүлэг, Ж.Батжаргал нарын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Ц.Сандаг-Очир: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “бүсэд” гэсний дараа “нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих инженерийн дэд бүтэц, барилга байгууламжаас бусад” гэснийг “бүсэд” гэсний дараа “инженерийн дэд бүтэц, нийтийн зориулалттай барилга байгууламжаас бусад” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Тав.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зургаа.Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Долоо.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Найм.Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав

Ц.Сандаг-Очир: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 16.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.7.Энэ хуулийн 16.6-д заасан тохиолдолд даатгагч энэ хуулийн 15.2-т заасан үүргээс чөлөөлөгдөх ба хохирогчийн эд хөрөнгөд учирсан хохирлыг барагдуулахдаа үнэлгээний тайлан шаардахгүйгээр эд хөрөнгийг засуулахаар тохиролцож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг саналаа тайлбарлаж үг хэлэв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав

Ц.Сандаг-Очир: 1.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 16.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.6.Даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохироогүй, холбогдогч талуудын тээврийн хэрэгслээс бусад эд хөрөнгийн хохиролгүй, холбогдогч талууд өөр хоорондоо маргаангүй тохиолдолд даатгагч, жолоочийн даатгалын сан нь даатгалын тохиолдлын талаарх мэдээлэл, баримтыг цахимаар даатгуулагч болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.6-д заасан автоматжуулсан системээс хүлээн авч, нөхөн төлбөрийг шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр саналаа тайлбарлаж, мөн дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл үг хэлэв.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Ес.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Арав.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Ц.Сандаг-Очир: 1.Төслийн 2 дугаар зүйлийн “7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн “албан тушаалтан” гэсний дараа “зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн оршин суугаа /оршин байгаа/ газар, эсхүл тухайн зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн” гэж,” гэснийг “7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн “харьяалах шүүхэд хүсэлт гаргана. ” гэснийг “харьяаллын дагуу зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн оршин суугаа /оршин байгаа/ газар, эсхүл тухайн зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн шүүхэд хүсэлт гаргана.” гэж,” гэж өөрчилж 4 дүгээр зүйлд шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Төслийн 4 зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Ц.Сандаг-Очир: 1.Төслийн 4 дүгээр зүйлийн “мөн зүйлийн 6.8 дахь заалтын “7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг,” гэснийг “7.1 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 7.6 дугаар зүйл, 7.7 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 7.9 дүгээр зүйл, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6,7 дахь хэсэг, 7.11, 7.12, 7.15, 7.17 дугаар зүйл,” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 5, 6 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, О.Цогтгэрэл, А.Ариунзаяа, Б.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа нарын өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгээс гаргасан танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлт болон ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолоолоор санал хураалт явуулав.

Нэг.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаар:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал:

Ц.Сандаг-Очир: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Н.Алтаншагай, П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Ө.Шижир, /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсгийн 27.5.1-27.5.7, 27.5.12, 27.5.14, 27.5.15 дахь заалтыг төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт болгон шилжүүлж, 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 27.5.8-27.5.11 дэх заалт, 27.5.13 дахь заалтыг хасаж, төслийн 4 дүгээр зүйлийн “32” гэж, гэсний дараа “27 дугаар зүйлийн 27.5.1 дэх заалтын “тагнуул болон гүйцэтгэх” гэснийг “тагнуулын болон цэргийн тагнуулын байгууллагын гүйцэтгэх” гэж, гэж, мөн зүйлийн “23.9-23.12” гэж, гэсний дараа “27 дугаар зүйлийн 27.5.1 дэх заалтын дугаарыг “27.5.10” гэж, 27.5.2, 27.5.3 дахь заалтын дугаарыг “27.5.8, 27.5.9” гэж, 27.5.4, 27.5.5 дахь заалтын дугаарыг “27.5.11, 27.5.13” гэж, гэж нэмж, төсөлд доор дурдсан агуулгатай 7 дугаар зүйл нэмэх:

“7 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 27 дугаар зүйлийн 27.5.12 дахь заалтыг, 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 27 дугаар зүйлийн 27.3.6 дахь заалтын “Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын,” гэснийг, 4 дүгээр зүйлийн 27 дугаар зүйлийн 27.5.1 дэх заалтад орсон өөрчлөлтийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	7
Бүгд:	17

58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаар:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2 дахь заалтын дагуу хураалгах санал:

Ц.Сандаг-Очир: 1.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн “70 дугаар зүйлийн” гэсний өмнө “64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсгийн “Тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “Ерөнхий сайд” гэж, 69 дүгээр зүйлийн 69.2 дахь хэсгийн “хоёр” гэснийг “гурав” гэж, гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	6
Бүгд:	17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмж, 5, 6, 7 дугаар зүйлийн дугаарлалтыг өөрчлөх:

“5 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.9 дэх хэсгийн “энэ хуулийн 71.13-т заасан дүгнэлтийн хамт” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаар:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2 дахь заалтын дагуу хураалгах санал:

Ц.Сандаг-Очир: 1.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн “тухай хуулийн” гэсний дараа “21 дүгээр зүйлийн 21.3.1 дэх заалтын “нэг дэх” гэснийг “нэг, хоёр дахь” гэж, 21.3.2 дахь заалтын “хоёр” гэснийг “гурав” гэж” гэж, мөн зүйлийн “24 дүгээр зүйлийн” гэсний өмнө “23 дугаар зүйлийн гарчгийн, 23.1 дэх хэсгийн “нэг дэх” гэснийг “нэг, хоёр дахь” гэж, мөн зүйлийн 23.3 дахь хэсгийн “нэг дэх” гэснийг “хоёр дахь” гэж, 24 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 24.1 дэх хэсгийн “Хоёр” гэснийг “Гурав” гэж,” гэж, мөн зүйлийн ““Тамгын газрын” гэсний өмнө “25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийн” гэж нэмж, мөн зүйлийн “Энэ хуулийн 22.1.2, 22.1.3-т заасан асуудлаар” гэснийг, мөн зүйлийн “энэ хуулийн 22.1-д заасан асуудлаар” гэснийг, төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн “тухай хуулийн” гэсний дараа “14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтын “Ерөнхий сайдын сар бүрийн” гэснийг “Улсын Их Хурлын асуулгын хүрээнд хийх” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2 дахь заалтын дагуу хураалгах санал:

Ц.Сандаг-Очир: 1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2 дахь заалтын дагуу хураалгах санал:

Ц.Сандаг-Очир: 1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнг Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргад нэр дэвшүүлж байгаа талаар танилцуулав.

Танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижирийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд үг хэлээгүй болно.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирыг Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргаас чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэнг тус дэд хорооны даргаар сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир “Дэд хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулав.

Ц.Сандаг-Очир: “Дэд хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 20 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 11 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 04-ны өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 10 цаг 05 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралдааныг эхлэхэд бэлэн болсон байна. Ирцийг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанд Жадамбаагийн Бат-Эрдэнэ, Батын Батбаатар гишүүн, Баярмагнайн Баярбаатар гишүүн, Жудгийн Баярмаа гишүүн, Энхбатын Болормаа, Сархадын Зулпхар, Лхагвын Мөнхбаатар, Одсүрэнгийн Номинчимэг, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Гончигдоржийн Уянгахишиг, Өлзийхүүгийн Шижир, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүд ирсэн байна.

52 хувьтай болсон учраас 7 дугаар сарын 4-ний өдрийн Байнгын хорооны хуралдаан нээснийг мэдэгдье ээ. Би бичээд л гишүүд танхимдаа ирээрэй. Танхимд Энх-Амгалан гишүүн, Шижир гишүүн, Уянгахишиг гишүүн гишүүн, Номинчимэг гишүүд байна. Ирцдээ орсон гишүүд танхимдаа ирэхийг урьж байна. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэнэ.

1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал.

2.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газар 2025 оны 6 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг

3.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, О.Цогтгэрэл, А.Ариунзаяа, Б.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа нарын гишүүд өргөн мэдүүлсэн нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу?

Миний бие нэг хэлэлцэх асуудлыг нэмж оруулж байна. Өнөөдрийн хэлэлцэх асуудалд.

Миний бие Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд байдаг Халдашгүй байдлын дэд хорооны даргаар ажилладаг.

Ингээд Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар томилогдсонтой холбогдуулж Халдашгүй байдлын дэд хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн байгаа.

Тийм учраас өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудалд Халдашгүй байдлын дэд хорооны даргыг сонгох асуудлыг хэлэлцүүлэхээр оруулж ирж байгаа юм аа.

Ийм 4 асуудал байгаа. Саяын 4 дэх асуудлыг өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураана.

Гишүүд танхимдаа орж ирээрэй. Оюунсайханы Алтангэрэл гишүүн чуулгандаа ирээрэй. Дашзэвэгийн Амарбаясгалан гишүүн, Сайнбуянгийн Амарсайхан гишүүн, Сандагийн Бямбацогт гишүүн, Лувсаннъямын Гантөмөр гишүүн, Тогмидын Доржханд гишүүн, Нямтайширын Номтойбаяр гишүүн, Эрдэнэбилигийн Одбаяр гишүүн, Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Цэвэгдоржийн Туваан, Ням-Осорын Учрал, Одонгийн Цогтгэрэл нарын гишүүд Байнгын хорооныхоо хуралдаанд ирээрэй.

Санал хураах гээд байна. Байнгын хорооны хэлэлцэх асуудлын хүрээнд.

Бямбацогт дарга аа, Баярмаа гишүүн ээ, санал хураах гэж байна. Хэлэлцэх асуудал дээр саяын танилцуулсан 3 асуудал дээр нэмэх нь Байнгын хорооны даргын зүгээс өнөөдрийн хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд Халдашгүй байдлын дэд хорооны даргыг чөлөөлж, сонгох асуудлыг горимын саналаар нэмж оруулж байгаа юм аа.

Тийм учраас 4 дэх асуудлыг Байнгын хорооны хэлэлцэх асуудалд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явах гэж байна. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй.

Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд 4 дэх асуудлыг танилцуулсан.

Хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

14 гишүүнээс 9 гишүүн дэмжиж 64.3 хувиар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд 4 дэх асуудлыг орууллаа. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан ТББХ хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан.

Үүнтэй холбогдуулаад Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийтийн өмчийн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах бусад хууль тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

14 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 71.4 хувиар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүнээс 2025 оны 7 сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

64.3 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын хоёр 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

10.13 цаг

Нэг дэх асуудал дууслаа.

Одоо 2 дахь асуудалд орёё.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газар 2025 оны 6 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлгийг явуулъя аа.

Ажлын хэсгээ өг дөө. Ажлын хэсгийг танилцуулъя.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Нямбаатар, НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Үнэнбат, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх Баттөгс.

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг гишүүн танилцуулна аа. Номинчимэг үү? Номинчимэг гишүүн танилцуулна.

Ц.Сандаг-Очир: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг асуудлыг 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд хэлэлцүүлгийн явцад хуралдаан даргалагчаас дээрх хуулийн төслүүдийг холбогдох Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлэх чиглэл өгсөн.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10 дахь хэсэгт заасан Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг ХЗБХ 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаар явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 2 саналын томьёолол гаргасан бөгөөд саналын томьёоллыг Байнгын хорооны хуралдаанаар оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Нийслэл Улаанбаатар хотын замын төв хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Номинчимэг гишүүнд баярлалаа.

Одоо Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ гишүүн танилцуулна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах гэр хорооллын орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн

төслүүдийг Улсын Их Хурал 2025 оны 07 сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж төслүүдийн анхны хэлэлцүүлгийг бэлтгүүлэхээр, ТББХ болон холбогдох Байнгын хороодод шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн хамт өргөн мэдүүлсэн Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тухай, Усны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүр бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн М.Ганхуяг, Ж.Батжаргал, Ц.Мөнхбат, Ж.Бат-Эрдэнэ, Л.Мөнхбаясгалан, Г.Ганбаатар, Ц.Идэрбат нар хууль санаачлагчаас асуулт асууж, хариулт авлаа.

Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, М.Ганхүлэг, Ж.Батжаргал нар төслийн 1 дүгээр зүйлийн бусад гэсний дараа нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих инженерийн дэд бүтэц барилга байгууламжаас “бусад” гэсний дараа инженерийн дэд бүтэц нийтийн зориулалттай барилга байгууламжаас бусад гэж өөрчлөх санал гаргаж “Улаанбаатар хот” гэснийг хасаж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно оо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Тэргүүн шадар сайд Тогмидын Доржханд гишүүн танилцуулна.

Т.Доржханд: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурал 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороодод шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийг баримтлан Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа нь бусад хуультай хэрхэн нийцэж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд уг хуулийн төсөлд өөрчлөлт орсноор арилжааны банкуудаас хувийн хэвшилд олгодог зээлийн хэмжээний өөрчлөлтийн талаар Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж такси үйлчилгээ эрхлэгчид өгөх татаас, такси үйлчилгээг нэг стандарттай болгох талаар болон авто тээврийн хяналтын аль хэсгийг нийслэлийн удирдлагад шилжүүлэх, ЗТЯ-ны авто тээврийн хяналтын талаар асуулт асууж хариулт авлаа.

Байнгын хорооны хуралд оролцсон гишүүдээс хуулийн төслүүдтэй холбогдон зарчмын зөрүүтэй санал гаргаагүй болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жолоочийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Доржханд гишүүнд баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа гишүүн танилцуулна. Х.Болормаа гишүүний микрофоныг өгье.

Х.Болормаа: ТББХ-ны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 сарын 20-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 7 сарын 2-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн Байнгын хороонд шилжүүлсэн.

Хуулийн төсөлд нийслэлийн гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагаа газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж байгаа иргэн, хуулийн этгээдийн нөхөн олговрын санхүүжилтийг шийдвэрлэх сан байхгүй учраас хууль хоорондын зөрчлийг арилгах мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийслэл, аймагт нийтийн тээврийн хэрэгсэл, таксинаас бусдаар үнэ төлбөргүй зорчсоны төлбөрийг харьяалал харгалзахгүйгээр тухайн аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлж байх зохицуулалтыг тусгасан байна аа.

Төсвийн байнгын хороо 2025 оны 7 сарын 4-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу явуулж хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүд асуулт, санал гаргаагүй болно.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Болормаа гишүүнд.

Ингээд Байнгын хороодын санал, дүгнэлтийг уншиж танилцуулж дууслаа.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэнэ ээ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Зарчмын зөрүүтэй санал байгаа юу? 1 дүгээр зүйл дээр байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Зарчмын зөрүүтэй санал байна уу? Байхгүй байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулттай саналтай гишүүн байна уу?

Алга байна. Зарчмын зөрүүтэй санал байна уу? Зарчмын зөрүүтэй 2 санал байна.

Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг гишүүнээс Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан төслийн 3 дугаар зүйлийг энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэж өөрчлөх. Уянгахишиг гишүүн гаргасан зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлах уу?

Г.Уянгахишиг: Төсөл дээр нөгөө 7 сарын 1-ээс 25 оны 7 сарын 1-ээс гэгчихсэн байгаа юм.

Тэгэхээр нөгөө 7 сарын 1 маань өнгөрчихсөн учраас баталсан өдрөөс гэдгээр өөрчилж байгаа гэсэн үг.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсэг. Ажлын хэсгийн 5 номерын микрофон. Хотын дарга Нямбаатар дарга.

Х.Нямбаатар: Тийм. Баталсан өдрөөсөө гээд. Сандагаа дарга. Үнэнбат дарга хариулчихъя. Энэ нөгөө нэг Цэцтэй холбоотой бас нэг юм байгаа.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 4 номерын микрофон. Үнэнбат дарга.

М.Үнэнбат: Тэгэхээр Уянгахишиг гишүүний саналтай санал байна нөгөө хугацаа өнгөрсөн учраас.

Тэгэхдээ баталсан өдрөөс гэдэг томъёоллоор орохоор ҮХЦ-ийн бас нэг дүгнэлт байдаг. Хуулийг баталсан өдрөөс дагаж мөрдөнө гээд заахаар Ерөнхийлөгчийн хориг тавих хугацааг энэ дээр анхаарахгүй байна гэсэн ийм зохицуулалт байдаг. Энийгээ анхаарна уу гэдэг учраас хугацааны хувьд нэг яг Ерөнхийлөгчийн хоригийг тооцоод хугацаа тавивал 8 сарын 1 эсвэл 7 сарын 15 гэхэд илүү зохимжтой болов уу гэж бодож байна.

Ц.Сандаг-Очир: Хэд болох нь үү тэрийг тооцохоор. 8 сарын 1.

Болж байна уу Уянгахишиг гишүүн тийм болж байна. Тэгвэл ойлголцоод төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн Уянгахишиг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Энэ санал хураалтдаа бэлдэх юм байна гишүүд ээ.

3 дугаар зүйлийг хасъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

16 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 81.3 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйл дээр ахиад Уянгахишиг гишүүний 2 дахь санал байна.

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.7¹ дүгээр зүйлийн 7¹.2.1 дэх заалтыг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг гишүүн. Уянгахишиг гишүүн саналаа тайлбарлая.

Г.Уянгахишиг: Энэ дээр нөгөө орон нутгийн төсвөөс эх үүсвэртэй сан байхаар заавал Төсвийн хууль руу орох ёстой. Тэгээд нэгжийн хууль дээрээ яг энэ төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна гэдэг заалт нь 2026 оны 6 сарын 1-ээс хүчин төгөлдөр мөрдөгдөхөөр байгаад байгаа юм. Тэгэхээр яг одоо шууд энгийн ердийн журмаар энэ заалт бусадтайгаа адилхан явчихаар хуулийн зөрчил үүсчих гээд байгаа учраас яг энэ заалтаа тэр нөгөө 2026 оны 6 сарын 1-ээсээ гэдэгтэйгээ уялдуулаад оруулчихъя гэж байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Уянга хишиг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй гаргасан саналын томъёоллоор. Хууль санаачлагч юу гэж үзэж байгаа юм Нямбаатар дарга аа. Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Х.Нямбаатар: Уянгахишиг гишүүний гаргасан саналыг дэмжиж байгаа. Төсвийн хуультайгаа уялдуулаад явъя гээд. Тэгвэл хишиг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй 2 дахь саналаар санал хураалт явуулъя.

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

16 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 81.3 хувиар санал дэмжигдлээ.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Одоо дагасан Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ ээ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал байгаа юу? Байхгүй байна. Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу алга байна. Зарчмын зөрүүтэй санал алга байна.

Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал алга байна. Агаарын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулттай саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал алга байна. Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулттай саналтай гишүүн байна уу, байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй санал байхгүй байна.

Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал байхгүй байна.

Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг хэлэлцье.

Тус хуулийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Усны тухай хууль. Зарчмын зөрүүтэй санал байна.

Байгаль орчны байнгын хорооны дэмжсэн санал байгаа юм байна.

Мөн Батбаатар гишүүний санал гээд 2 санал байгаа юм байна. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “бүсэд” гэсний дараа “нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих инженерийн дэд бүтэц барилга байгууламжаас бусад” гэснийг “бүсэд” гэсний дараа инженерийн дэд бүтэц, нийтийн зориулалттай барилга, байгууламжаас бусад” гэж өөрчлөх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, М.Ганхүлэг, Ж.Батжаргал, мөн Батбаатар гишүүний гаргасан Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Усны тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн ийм 2 санал гаргасан байна.

Байнгын хорооны саналаар Төслийн 1 дүгээр зүйлд заасан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Ганхүлэг, Батжаргал нарын гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Үг хэлэх үү?

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд гаргасан дэмжсэн санал дээр Уянгахишиг гишүүн асууя.

Г.Уянгахишиг: Энэ дээр нэг ийм асуудал үүсчхээд байна аа. Нөгөө нийтийн барилга байгууламжаас бусад гэххээ байгаа байхгүй юу. Тэгэхээр нийтийн барилга байгууламж гэдэг дотор яг хуулиараа ямар барилга байгууламжууд орох вэ? Уг нь бид нар зөвхөн инженерийн дэд бүтцийн тухай яриад байна гэж ойлгоод байгаа байхгүй юу. Гэтэл инженерийн дэд бүтэц, нийтийн барилга байгууламж гэхихээр нөгөө орон сууцын барилгууд чинь энэ онцгой хамгаалалтын бүс дээр баригдах тухай асуудал үүсчхээд байгаа гэсэн үг.

Тэгэхээр энэ талаар асуулга асууя. Тэгээд хэрвээ энэ томъёолол өөрчлөгдөх ёстой бол хууль санаачлагчдаас гүйцээн боловсруулах ч юм уу аваад нэг томъёоллын нь өөрчлөхгүй бол арай л болохгүй юм шиг харагдаад.

Ц.Сандаг-Очир: Уянгахишиг гишүүний асуултад ажлын хэсгийн 5 номерын микрофон. Хотын дарга Нямбаатар дарга. Хэрвээ Байгаль орчны сайд Батбаатар даргын санал болгосноор энэ хуулийг бид нарыг буцааж тат гэвэл Туулын хурдны зам баригдахгүй. Тойрог хурдны зам баригдахгүй. Одоо манайд баригдаад байгаа бүх гүүрүүд Усны тухай хуулийг зөрчиж барилга баригдаж байгаа. 2015 онд Барилга хот байгуулалтын сайд Байгаль орчны сайд 2 хамтраад Усны тухай хуулиа давсан журам гаргаад тэр журмаараа гол дээгүүр голын онцгой хамгаалалтын бүсэд гүүрэн байгууламжууд тэр байтугай барилга байгууламжууд бариад байгаа юм.

Уянгахишиг гишүүний асуултад хариулахад бид нар хурдны зам барихад хурдны зам дагасан инженерийн барилга нийтийн зориулалттай барилга байгууламжууд баригддаг тухайлах юм бол төлбөр хураах цэгийн барилга байгууламжууд голын тэр инженерийн барилга байгууламжийг давсан цэвэр бохир усны шугам сүлжээнүүд, түүнтэй холбоотой адилтгах барилга байгууламжуудыг л ойлгож байгаа.

Тийм учраас өчигдөр бид нар Байгаль орчны байнгын хороон дээр яг энэ дэд бүтэц нийтийн зориулалттай барилга байгууламж гэдэг агуулгаар оруулахгүй бол дээр нь нэг ширхэг ч тоосго өрж болохгүй. Зөвхөн шугам шугам сүлжээгээ ойлгохоор байгаа. Үүнийг Барилгын тухай хууль болон бусад хуультай нийцүүлж өчигдөр саналын томъёоллыг Байгаль орчны байнгын хороон дээр хураасан.

Тийм учраас Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүдийг Байгаль орчны байнгын хороон дээр дэмжигдсэн саналыг дэмжиж өгнө үү гэж хүсэж байна.

Ц.Сандаг-Очир: Уянгахишиг гишүүн тодруулъя.

Г.Уянгахишиг: Тэгэхээр ядаж протоколдоо тусгамаар байна л даа. Яг энэ нийтийн зориулалттай барилга байгууламж гэдэг нэр томъёо ямар хууль дээр байгаа вэ? Яг тэр барилгын би энэ дээрээс баахан хайгаад олсонгүй л дээ. Тэгэхээр Барилгын тухай хуулийн тэдийн тэдэд заасан нийтийн барилга байгууламжийг энд ойлгоод байгаа юм аа. Энэ дотор бол орон сууцын барилга энэ тэр орохгүй юм гэдгээ аягүй сайн тодорхой хэлэхгүй бол буцаад дараа нь энэний цаана яг ийм нөхцөл байдлыг бид нар онцгой хамгаалалтын бүсдээ үүсгэхийг вий дээ л гэдэг.

Нямбаатар дарга ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Х.Нямбаатар: Уянгахишиг гишүүн таны асууж байгаа асуулт, миний хариулж байгаа хариулт болгон энэ хуулийн хувийн хэрэг протоколд хадгалагдаж байгаа. Өөрөөр хэлбэл би дахиад хариуцлагатайгаар хэлье. Нийтийн зориулалттай барилга байгууламж гэдэгт амины орон сууц, нийтийн орон сууц гэдэг ойлголт хамрагдахгүй ээ. Энд зөвхөн нийтийн зориулалттай гүүрэн байгууламж түүнийг дагасан барилга байгууламжуудыг хамтатгаж ойлгоно оо.

Хэрвээ энэ асуудлаар дараа нь нийтийн зориулалттай амины орон сууц хувийн орон сууц баригдсан тохиолдолд Үндсэн хуулийн цэц дээр уг асуудал маань

хуулийн хувийн хэргээ дагаж шийдэгдэж явах учраас энэ дээр та санаа зовохгүй байж болно гэж би товчхондоо хариулъя.

Ц.Сандаг-Очир: Ахиад тодруулъя гэж байна. Уянгахишиг гишүүн нэг минут.

Г.Уянгахишиг: Одоо яг энэ Барилгын тухай хууль дээр байгаа л даа 4.1.1 дээр. Барилга байгууламж гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээ гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь урд талд нь нийтийн зориулалттай гэдэг тодотгол орж ирлээ. Тэрнээс биш барилга байгууламж гэдэг чинь үг чинь байгаад байна шүү дээ.

Тэгэхээр энэ дотор орон сууц орох гээд байна гэдэг ийм асуудлыг тавиад хөндөөд байгаа юм шүү. Энэ дээр харин зүгээр инженерийн дэд бүтэц, инженерийн дэд бүтцийн барилга байгууламж гэвэл арай өөр болно. Тэрнээс биш яг барилга байгууламж гэдэг утгаараа явах юм энэ дотор орон сууцын барилга орох гээд л байгаа гэсэн үг.

Ц.Сандаг-Очир: 5 номерын микрофон хотын дарга Нямбаатар дарга.

Х.Нямбаатар: Энэ СӨХ-ны тухай хуулийн уг нь 3 дугаар зүйлд нийтийн зориулалттай орон сууц энэ тэр гэдгээ тодорхойлчихсон байгаа байхгүй юу Уянгахишиг гишүүн ээ. Бид нар энийг нийтийн зориулалттай дэд бүтэц барилга байгууламж гэж СӨХ-ны тухай хуулийн 3 дугаар зүйлээс ялгаж ингэж зориуд өөрсдөө санал гаргаж хураалгасан шүү дээ.

Тийм учраас энийг ингээд яг Байнгын хорооных нь саналаар санал хураалгачихмаар байна л гэсэн саналыг хэлье. СӨХ-ны тухай хуулийн 3 дугаар зүйлд нийтийн зориулалттай орон сууц гэдгийг чинь бүр тодорхойлоод өгчихсөн. Тэрнээс бид нар ялгахын тулд нийтийн зориулалттай барилга байгууламж гэж тусад нь оруулж ирсэн юм аа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо та өөрийнхөө эндээс үү нэрээ өгөөгүй байна даа. Батбаатар гишүүн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоо тайлбарлая.

Б.Батбаатар: Яах вэ ер нь бол түрүүн Нямбаатар дарга хэлж байна. Барилгын сайд, Байгаль орчны сайд 2 хамтарсан журам гаргаад хуулиасаа давсан журам гаргаад гүүрэн байгууламжууд, зам тээвэр ингээд баригдсан гэж. Тэгэхээр тэр журмаа 1 дүгээрт нь хүчингүй болгосон юм уу?

Хоёрдугаарт нь энэ Улаанбаатар хотод голын эрэг энэ хамгаалалтын бүсийг ингээд эвдчихээр бусад аймаг сум төвлөрсөн газар энэ бас эвдэгдэнэ ээ. Байгаль орчны салбарын багц хуулийг намрын чуулганд өргөн барьж хэлэлцүүлэхээр бэлдэж байна. Нөгөө журам нь хүчинтэй хүчингүй байгаа асуудал. Тэгэхлээр энэ зүйлийг ингээд хууль санаачлагчид нь буцааж байгаад бид нар ярихгүй бол эдийн засаг хүндэрсэн асуудал болсон үед нэг номерт нь хамгийн түрүүн байгалиа дээрэмддэг. Нэг бол ирээдүй хойч үедээ өр тавьж зээл авдаг. Энэ 2 зам руу л ордог.

Тусгай хамгаалалттай бүсүүд рүү халдах. Алтны уурхай ажиллуулах гол мөрний сав газар энэ голын эрэг дээр байшин барилга, инженер, дэд бүтэц, бусад

зүйлийг нээх. Энэ олон асуудлууд үүсээд ирвэл энэ ингээд байгаль хамгааллын асуудал маань өөрөө хаягдаад гээгдээд эхэлнэ ээ.

Тийм болохоор зарчмын зөрүүтэй санал дээр бид нар олон эдийн засгийн чухал зүйлийг ярьдаг хэрнээ улс оронд ирээдүйд үр хүүхдэд үлдэх байгаль орчин, ус, гол мөрөн, ой газар нутгаа бас бодож байхгүй бол болохгүй. Хууль санаачлагчид энийг буцаая гэсэн ийм саналтай байгаад байгаа юм аа энэ дээр.

Ц.Сандаг-Очир: Санал хэллээ.

Ингээд санал хураалт эхэлье. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй байнгын хорооны дэмжсэн саналаар дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

17 гишүүнээс 10 гишүүн дэмжиж 58.8 хувиар санал дэмжигдлээ. Түрүүлж гаргаснаар нь Байнгын хорооны саналыг санал хураалгая.

Усны тухай хуулийн 1 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа.

Усны тухай хуулийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй санал байгаа юу? Байхгүй байна. Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал байна уу? 1 дүгээр зүйл дээр. Байхгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал байгаа юу? Байхгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналын томъёолол алга байна. Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй санал байхгүй байна. Авто тээврийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал алга байна.

Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал байхгүй байна. Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй санал байхгүй байна.

ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй санал байна уу? Байхгүй байна.

ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал байхгүй байна.

ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал алга байна.

ЗХАБТХ-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 5 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал алга байна.

6 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал алга байна.

7 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал алга байна.

ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Зарчим байна байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал байна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг гишүүний гаргасан саналыг уншиж танилцуулъя.

Энэ хуулийн 16.6-д заасан тохиолдолд даатгагч энэ хуулийн 15.2-т заасан үүргээс чөлөөлөгдөх ба хохирогчийн эд хөрөнгөд учирсан хохирлыг барагдуулахдаа үнэлгээний тайлан шаардахгүйгээр эд хөрөнгийг засуулахаар тохиролцож болно.

Улсын Их Хурлын гишүүн Батбаяр гишүүн 16.6.Даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас эрүүл мэнд хохироогүй холбогдогч талуудын тээврийн хэрэгслээс бусад эд хөрөнгийн хохиролгүй холбогдогч талууд өөр хоорондоо маргаангүй тохиолдолд даатгагч жолоочийн даатгалын сан нь даатгалын тохиолдлын талаарх мэдээлэл баримтыг цахимаар даатгуулагч болон ЗХАБТХ-ийн 1.6-д заасан автоматжуулсан системээс хүлээн авч нөхөн төлбөрийг шийдвэрлэнэ гэсэн. Батбаяр гишүүний гаргасан саналыг. Батбаяр гишүүн саналаа тайлбарлах уу?

Батбаяр гишүүн саналаа тайлбарлая.

Д.Батбаяр: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе.

Ажлын хэсгийнхэнд бас өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр ийм зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа юм. Гол нь даатгагч нар бизнесийн байгууллага мөн. Иргэдийн амьдралыг энэ илүү хөнгөвчлөх байдлаар нь оруулж өгөх ёстой юм байна. Тэгээд бид нар чинь технологийн дэвшлийг бүгдээрээ ашиглаж байгаа. Цахим хөдөлгөөнийх нь теле камерын тусламж гээд бүгдийг нь ... учраас аливаа маргааныг хэрвээ энэ эрүүл мэнд нь хохироогүй иргэдийн амь нас хохироогүй тохиолдолд шууд цахимаар хүлээж аваад хийчихдэг ийм илүү хөнгөн хэлбэр болгоё л гэсэн ийм утгатай санал байгаа.

Ц.Сандаг-Очир: Батбаяр гишүүний гаргасан саналыг ажлын хэсгээс тайлбар байна уу? Ажлын хэсгийн 5 номерын микрофон. Би сая уншсан даа.

Х.Нямбаатар: Тийм би Батбаяр гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг сая сонслоо. Ер нь бид нарын дэвшүүлж байгаа концепц нь ерөөсөө л Батбаяр гишүүний яг энэ санал. Өөрөөр хэлбэл нэг зөрчил дээр дунджаар 30-аас 40 минут даатгалын компани дуудаад тээврийн цагдаагийнхан ирж хэмжилт хийгээд ингээд яг тэр урсгалыг ингээд үндсэндээ 30-аас 40 минут хаагаад байгаа юм.

Тийм учраас хоорондоо зөвшилцөөд 2 тийшээгээ салж болно.

Хэрвээ маргаан дараа нь үүсэх юм бол цахим камерын хяналтын системээр хэн нь дүрэм зөрчсөн байна вэ гэдгийг зөрчлийн хэрэг нээгээд шалгаж шийдвэрлээд тэр дүгнэлтийг нь үндэслээд даатгалын компани нь хохирлыг нь барагдуулдаг болъё гэж байгаа юм. Хэн Уянгахишиг гишүүн болохоор шаардлагатай тохиолдолд тухайн даатгалын компани өөрөө очиж тухайн газар дээр нь маргааныг хянан шийдвэрлэхэд бас оролцож болох тэр боломжийг нээж өгье гэсэн. Тэгэхээр аль аль саналыг нь дэмжээд явж байгаа.

Ц.Сандаг-Очир: Тэгвэл Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр гаргасан Уянгахишиг гишүүний зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгая.

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

17 гишүүнээс 10 гишүүн дэмжиж 58.8 хувиар санал дэмжигдлээ.

Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр гаргасан Батбаяр гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

3 дээр нь асуучих тэгэх үү? Алтангэрэл гишүүн нөхөөд.

17 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 52.9 хувиар Батбаяр гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ. Өөр санал байгаа юу? Зарчмын зөрүүтэй санал байхгүй байна.

Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна зарчмын зөрүүтэй санал байгаа юу? 3.

Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: Тэгээд хэдүүлээ яах вэ нөгөө түгжрэл энэ тэрээ бодоод манай Нямбаа даргын ярьж байгаа энэ тэр зөв л дөө. Тэгэхдээ одоо энэ чинь аягүй хэрэгжүүлэхэд төвөгтэй юм батлах нь байна шүү дээ. Хоорондоо маргаангүй гэдгийг чинь хэн тодорхойлох юм. Яаж мэдэх юм? Шүргэлцдэг нэг нь бууж ирээд уурлаад байдаг нэг нь зүгээр байж байгаад хөдлөөд явчихдаг.

Дараа нь маргаантай байсан эсэхийг нь хэн тогтоох юм гэх мэтчилний энэ нэг ийм процедурын юман дээр их л ерөнхий юм явчихлаа. Тэгээд улам их хэрүүл дараа нь энэ асуудлаа шалгаж байгаа байгууллага нэн ялангуяа энэ тээврийн цагдаагийн албанд төвөгтэй байдал үүсэхээр их л ерөнхий юм баталчихлаа даа. Тэгээд дараа нь ийм үр дагавар үүсэх байх л гэж санаа зовж байна.

Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Алтангэрэл гишүүний гаргаж байгаа саналыг бас харгалзаарай протоколд бас тэмдэглэнэ биз.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйл дээр зарчмын зөрүүтэй санал алга байна.

Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу, байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал байна уу? Алга байна.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн алга байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал алга байна.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал байна уу? Байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал байна. Хэн гаргасан юм?

ХЗБХ-оос ирсэн ХЗБХ дэмжсэн санал байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн “7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн “албан тушаалтан” гэсний дараа “зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн оршин суугаа /оршин байгаа/ газар, эсхүл тухайн зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн” гэж,” гэснийг “7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн “харьяалах шүүхэд хүсэлт гаргана.” гэснийг “харьяаллын дагуу зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн оршин суугаа /оршин байгаа/ газар, эсхүл тухайн зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн шүүхэд хүсэлт гаргана.” гэж,” гэж өөрчилж 4 дүгээр зүйлд шилжүүлэх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг.

Сайнзориг гишүүн гаргасан саналаа тайлбарлах уу? Сайнзориг гишүүний гаргасан Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя гишүүд ээ.

Санал хураалт

17 гишүүнээс 12 гишүүн дэмжиж 70.6 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Зарчмын санал байхгүй байна. Хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

ХЗБХ-оос дэмжсэн Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг зарчмын зөрүүтэй санал гаргасан байна.

Төслийн 4 дүгээр зүйлийн мөн зүйлийн 6.8 дахь заалтын 7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэг 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг гэснийг 7.1 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 7.6 дугаар зүйл, 7.7 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 7.9 дүгээр зүйл, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг 7.11, 7.12, 7.15, 7.17 дугаар зүйл гэж гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг.

ХЗБХ дэмжсэн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

17 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 70.6 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийн 5 дугаар зүйл дээр асуух асуулттай гишүүн байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал алга байна.

Хуулийн төслийн 6 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал байхгүй байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг гишүүн танилцуулна.

10.53 цаг

Дараагийн 3 дахь асуудалд оръё.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, О.Цогтгэрэл, А.Ариунзаяа, Б.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа нарын гишүүд өргөн мэдүүлсэн нэгтгэсэн төсөл эцсийн хэлэлцүүлгийг явуулъя аа.

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг танилцуулна.

Нийслэл Улаанбаатар хот гээд дахиад энэ асуудал юм уу? Өөр байх тэ?

Г.Уянгахишиг: ТББХ-ны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн ТГ 01/829 тоот албан бичгээр ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслүүдийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо болон бусад хуультай зөрчилдсөн эсэх талаарх хууль

зүйн дүгнэлтийг ХЗБХ 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хууль зүйн дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын тэргүүн дэд дарга Ч.Ариунхур танилцуулсан болно оо. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслүүдийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо болон бусад хуультай зөрчилдсөн эсэх талаарх хууль зүйн дүгнэлтийг хуралдаанд орох болчихсон гишүүдийн олонх дэмжсэн болно оо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслүүдийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо болон бусад хууль хуультай зөрчилдсөн эсэх талаарх хууль зүйн дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Уянгахишиг гишүүнд баярлалаа.

Эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг гишүүдэд тараасан байгаа.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн ажлын хэсгийн ахлагч Баярбаатар танилцуулна аа.

Баярбаатар гишүүн микрофоныг өгье.

Б.Баярбаатар: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Нэр бүхий гишүүдийн өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэсэн төслийн анхны хэлэлцүүлгийг 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын даргын 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 288 дугаар захирамжаар байгуулагдсан хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг 2025 оны 7 сарын 3-ны өдөр хуралдлаа. Ажлын хэсэг нэгтгэсэн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.2-т заасан анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал болон хуулийн төслийн зүйл, хэсэг заалт нь өөр хоорондоо эс үгүй бол бусад хуультай зөрчигдсөн талаар хууль зүйн дүгнэлтийг Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаар дээр хэлэлцэн дэмжсэнтэй холбогдуулан 7 зарчмын зөрүүтэй саналын томьёолол бэлтгэлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллын агуулга дараах хүрээг хамарч байна аа.

1.Хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу Тусгай хяналтын дэд хорооны эрхлэх асуудалд оруулж буй тагнуулын болон цэргийн тагнуулын байгууллагын гүйцэтгэх ажлын талаарх хууль тогтоомжийн биелэлтийн талаарх өөрчлөлтийг 2026 оны 5 сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх.

Тэр хүртэл хугацаанд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Тусгай хяналтын дэд хорооны эрхлэх асуудал хэвээр үйлчлэх. Мөн нэгтгэсэн төсөлд тусгагдсан Хууль сахиулах ажиллагааны Тусгай хяналтын дэд хороо түүний эрхлэх асуудалтай холбогдох зохицуулалт болон Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн дагаж мөрдөх хуулийн хугацааг 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр санал бэлтгэлээ.

2.Хууль зүйн дүгнэлтэд тусгасан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэх дэгд өөрчлөлт орсон. Төсвийн төслийг 5 үе шаттайгаар хэлэлцэхээр тусгасантай холбогдуулан тус хууль болон бусад хуульд заасан зохицуулалтыг нийцүүлэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтын нийцлийг хангах санал бэлтгэлээ.

3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд Ерөнхий сайдын мэдээллийн цагийг хурлын асуулгын цаг болгон өөрчилсөнтэй холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд холбогдох өөрчлөлтийг оруулахаар бэлтгэлээ.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналыг нэгтгэсэн төсөлд нэмж туссан. Та бүхэнд тараагдсан болно оо.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхээсээ хүсье ээ.

Ц.Сандаг-Очир: Баярбаатар гишүүнд баярлалаа.

Танилцуулгатай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Байхгүй байна. Зулпхар гишүүн асууя.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа.

Би энэ яах вэ нөгөө аливаа хуулийн төслийг хэлэлцэх явцад нь ямар ч үед нь Улсын Их Хурлын гишүүд асуулт, асууж тайлбар авах ийм зохицуулалттай байгаа учраас энийг асууя гэж бодож байна аа.

Энэ хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр 1.4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсэг байгаа юм л даа. Энэ хууль санаачлагч өөрөө хариулж болно. Ажлын хэсэг хариулж болно.

Шинээр жишээ нь зүйл заалт нэмсэн байгаа юм. Нэгдсэн хуралдааны танхимын зохион байгуулалт нь Улсын Их Хурал хуралдаж хууль тогтоох хуулийн биелэлтэд хяналт тавих болон ард түмний элчийн хувьд Улсын Их Хурлын гишүүд одоо би эндээс уншина та бүхэн анхаараарай.

Дотор нь задлахаар зэрэг ингэж байгаа байхгүй юу. Нийт иргэн 2 дугаарт улсын ашиг сонирхлын өмнөөс үг хэлэх.

3 дугаарт нам, эвслийн бүлэг байр сууриа илэрхийлэх.

4 дүгээрт нь олонх цөөнх мэтгэлцэхэд зориулагдсан байна гээд ийм шинэ зохицуулалт ороод ирсэн байгаа юм. Ийм зохицуулалт ороод ирсэн байгаа юм.

Тэгэхээр энэ зохицуулалтыг би зүгээр гайхаад байна л даа. Одоо бид нар чинь энэ Их Хурлын танхимдаа ямар нэгэн байдлаар нийтийн эрх ашгийг төлөөлөөд эс үгүй бол үг хэлээд нам эвслийн бүлэг байр сууриа илэрхийлээд олонх цөөнх мэтгэлцэхэд ийм зохион байгуулалт байхгүй болоод ийм заалт орж ирээд байгаа юм уу ямар одоо жишээ нь зорилготой, ямар хүлээлттэй байгаа ийм заалт юм бэ гэсэн ийм тодруулга авмаар байна.

Энэ 1 дүгээр асуулт нь 2 дахь зүйл болохоор зэрэг яг одоо энэ хууль дээр хууль санаачлагчийн хувьд бас шинэ нэг тийм зохицуулалтууд оруулж ирсэн байна л даа.

30.21 дүгээр зүйлийн 21.25-аас 21.30 дахь хэсэг.

21.25 дээр ингэсэн байгаа юм. Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулгын танилцуулсан мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах болон Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно гэж тогтсон байгаа юм. Яах вэ энэ шинэ ийм практик юм шиг байгаа юм. Би энийг яагаад асуугаад байна гэхээр зэрэг яг одоо бусад манайхтай адилхан парламентын засаглалтай, Ерөнхийлөгчийн засаглалтай ч байж болно. Хамаагүй парламентад яг ийм зохицуулалт байна уу? Энэтэй уялдсан байдлаар 21.26, 21.27 дээр байгаа юм уу? 21.27 бүүр ингээд их шинэ практик орж ирж байна л даа. Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх албан тушаалтан болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон этгээд хариуцсан ажил үүргийн хувьд мэдэх, ёстой, мэдэх боломжтой мэдээллээ үнэн зөв бүрэн гүйцэд өгөх тухай сануулж баталгаажуулах гарын үсэг зуруулах ажлыг Тамгын газар зохион байгуулна гэсэн байгаа юм.

Тэгээд цаашдаа бол яах вэ орж ирээд дандаа ийм ийм практик руу орох юм байна гэж ойлгож байна шүү дээ. Хэн ч байсан ямар нэгэн хуулийн этгээд хувь хүн ч гэсэн мэдээлэл өгөх юм бол ийм байх юм байна. Энэ олон улсын ямар практик байгаа вэ гэсэн асуултыг би зориуд асууж байгаа юм. Энэ зүгээр тайлбар авч байгаа эд шүү. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Зулпхар гишүүний асуултад хууль санаачлагч Тэмүүжин гишүүн хариулна. Гишүүд энэ чинь бас эцсийн хэлэлцүүлэг явж байгаа шүү гэдгийг бас анхаарна биз. Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Тэр ер нь парламентыг үл хүндэтгэх парламентад худал мэдээлэл өгөх гэдэг энийг бүүр Эрүүгийн хуулиараа хориглосон ялтай зохицуулалттай улсууд олон байна лээ. Ардчилсан улс орнуудад. Америкт бол шүүхэд болон парламентад худал мэдээлэл өгөх, үл хүндэтгэх гэдэг нь хоёулаа 1 зүйл, заалтаар эрүүгийн гэмт хэрэг байх жишээтэй. Германд бол бас парламентыг үл хүндэтгэх худал мэдээлэл өгөх бол эрүүгийн гэмт хэрэг байна лээ. Зүгээр бид одоогоор эрүүгийн гэмт хэрэг ерөөсөө бичээгүй. Зүгээр энэ наана нь менеж хийх зорилготой зохицуулалтуудыг хийж байгаа. Парламентад Улсын Их Хурлын гишүүнээс бусад хүмүүс үг хэлнэ гэдэг ойлголт байдаггүй юм байна лээ. Тайлбар, мэдээлэл өгнө. Тайлбар гэх мэтчилэн.

Монгол Улсын Үндсэн хууль дээр ч гэсэн мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийг хүртэл мэдээлэл өгнө гэж бичсэн байна лээ. Үг хэлнэ гэж ерөөсөө бичээгүй. Яагаад ингэж бичиж байгаа юм бэ гэхээр парламентын гишүүд хэлсэн үгийнхээ төлөө дэвшүүлсэн бодлогынхоо төлөө Улсын Их Хурал дээр хэлсэн үг, дэвшүүлсэн бодлогынхоо төлөө хариуцлага хүлээхгүй гэдэг энэ нөгөө улс төрийн асуудалд ямар нэгэн шүүхийн маргаан эс үгүй бол гэмт хэрэг болгож өөр бусад засаглал хөндлөнгөөс орж ирэхээс хамгаалах зорилготой ийм зохиц зохицуулалт байдаг юм байна лээ.

Парламентын гишүүдээс бусад хүн бол ерөөсөө үг хэлэх тухай ойлголт байхгүй. Мэдээлэл өгнө. Энэ мэдээллийн үнэн зөвийг өөрөө хариуцна. Мөн парламентад үнэн зөв мэдээлэл өгөхтэй холбоотой ийм сануулах хуудсан дээр гарын үсэг зурах ийм жишиг байгаад байгаа юм. Тэгээд энэ бол ер нь бол шийдвэр гаргалтыг илүү бодитой алдаа мадаггүй гаргахад зориулсан зохицуулалтын л нэг дэвшилтэт арга байгаад байгаа. Тэгээд энэ агуулгаар нь оруулж ирсэн.

Эхний асуулт болохоор Монгол Улсын Үндсэн хууль дээр маш тодорхой заасан. Улсын Их Хурал 126 гишүүнээс бүрдэнэ. 126 гишүүн хуралдааны хэлбэрээр үйл ажиллагаа явуулна. Тэгээд Байнгын хороо болон чуулганы хэлбэрээр хуралдаан зохион байгуулагдана гэсэн ийм зохицуулалттай. Энэ 126 хүн ямар байдлаар ажиллах вэ гэдэг нь нарийвчилсан зарим нэг зохицуулалтууд дутмаг байсан учраас эхний ерөнхий тэр заалт орсон. Үзэл бодлоо илэрхийлэх, байр сууриа илэрхийлэх, олон цөөнхөөрөө ажиллах гэх мэтчилэн энэ зохицуулалтууд зохицуулалтын тухай орж ирсэн. Яг хуучин байгаа заалт дотор нэг алдаатай үгийг бас зассан байгаа.

Улсын Их Хурлыг төлөөллийн дээд байгууллага гэж томъёолсон байна лээ. Хуучин Улсын Их Хурлын тухай хууль дээрээ. Тэрийг нь бол засаад энэ бол төрийн эрх барих дээд байгууллага. Засгийн бүх эрх ард түмнээс үүснэ л дээ. Тэр үүсгэлдээ засгийн эрх мэдлийг барьдаг төлөөллийн байгууллагын нэг хэлбэр мөн боловч энэ

төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурал Дангаар хууль тогтоох эрх мэдлийг авна гэдэг энэ үндсэн хуулийн томъёоллоор нь засаж оруулж ирсэн байгаа.

Ц.Сандаг-Очир: Зулпхар гишүүн тодруулъя, нэг минут.

С.Зулпхар: Тэмүжин гишүүнд баярлалаа. Би яах вэ зүгээр зориуд хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх үүднээс асуугаад байгаа юм шүү дээ.

Тэгэхээр одоо хууль бол 2 хэлбэрээр л нэг зохицуулагдаагүй харилцааг зохицуулах үүднээс бид нар бий болгодог. Нэг бол шинээр ямар нэгэн харилцааг бий болгох үүднээс бид нар чинь хууль боловсруулж батлуулдаг гэдэг ийм л ойлголттой шүү дээ.

Тэгэхээр энэ аль нь вэ гэж байгаа юм. Байхгүй харилцааг зохицуулах гээд байна уу? Байгаа харилцаа нь зохицуулагдаагүй байгаа учраас энийг боловсронгуй болгох гээд байна уу гэдэг талаас нь бас та хуульч хүн юм чинь таны хариултыг сонсьё.

Ц.Сандаг-Очир: Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Хууль гарах олон шалтгаан байгаа. Тэрний нэг нь хэрвээ зохицуулалт алдаатай байгаа бол түүнийг засах ёстой. Зохицуулалт дутмаг байгаа бол түүнийг нөхөх ёстой. Зохицуулалт өөр хоорондоо зөрчилдөөд байгаа бол аль нэг зохицуулалтыг нь дэмжиж нөгөөдхийг нь зогсоох ёстой.

Зарим талаараа нөгөө хуулийн дотор эрэмбэ байгаа. Үндсэн хуульд нийцээгүй юм уу Үндсэн хуулийн утга санааг бүрэн илэрхийлээгүй зохицуулалтуудыг сайжруулах ёстой.

Тэгэхээр энэ агуулгуудын хүрээнд л орж ирж байгаа. Нийгмийн харилцааг зохицуулах дан хуулиар зохицуулахгүй олон зүйлийн зохицуулалт байгаа.

Гагцхүү шүүхэд маргаан гаргах эс үгүй бол нэгдсэн байдлаар нэг зохицуулалттай болоход мэдээлэл ойлголтыг түгээхийн тулд хууль илүү нөгөө давуу хүчинтэй хэм хэмжээнийхээ хувьд тодорхойлж өгдөг ойлголтуудыг нэгтгэх. Хэм хэмжээг дэс дарааг зөв эрэмбэлэх, нийгмийн харилцаанд зарим талаараа төрийн албадлагыг ашиглахад зориулагдаж гардаг.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо зарчмын зөрүүтэй саналаар санал хураана. 7, 8 санал байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу хураалгах саналыг.

1.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсгийн 27.5.1-ээс 27.5.7, 27.5.12, 27.5.14, 27.5.15 дахь заалтыг төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт болгон шилжүүлж 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 27.5.8-аас 27.5.11 дэх заалт, 27.5.13 дахь заалтыг хасаж, төслийн 4 дүгээр зүйлийн 32 гэж гэсний дараа 27 дугаар зүйлийн 27.5 дахь заалтын тагнуулын болон гүйцэтгэх

гэснийг тагнуулын болон цэргийн тагнуулын байгууллагын гүйцэтгэх гэж гэж мөн зүйлийн 23.9-өөс 23.12 гэж гэсний дараа 27 дугаар зүйлийн 27.5.1 дэх заалтын дугаарыг 27.5.10 гэж, 27.5.2, 27.5.3 дахь заалтын дугаарыг 27.5.8, 27.5.9 гэж 27.5.4, 27.5.5 дахь заалтын дугаарыг 27.5.11, 27.5.13 гэж нэмж төсөлд доор дурдсан агуулгатай 7 дугаар зүйл нэмэх:

7 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 27 дугаар зүйлийн 27.5.12 дахь заалтыг 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 27 дугаар зүйлийн 27.3 дахь заалтын Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын гэснийг 4 дүгээр зүйлийн 27 дугаар зүйлийн 27.5.1 дэх заалтад орсон өөрчлөлтийг 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Санал хураалт.

Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй.

Санал хураалт.

17 гишүүнээс 10 гишүүн дэмжиж 58.8 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2-т заасны дагуу хураалгах санал.

1.Нэгтгэсэн төслийн чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн 70 дугаар зүйлийн гэсний өмнө 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсгийн тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гэснийг Ерөнхий сайд гэж, 69 дүгээр зүйлийн 69.2 дахь хэсгийн 2 гэснийг 3 гэж нэмэх.

Санал хураалт.

17 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 64.7 хувиар санал дэмжигдлээ.

2 дахь санал хураалт.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал.

2 дахь санал.

Нэгдсэн төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмж, 5, 6, 7 дугаар зүйлийн дугаарлалтыг өөрчлөх:

“5 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.9 дэх хэсгийн “энэ хуулийн 71.13-т заасан дүгнэлтийн хамт” гэснийг хассугай.”

Санал хураалт.

64.7 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалт хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол 1.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2 дахь заалтын дагуу хураалгах санал:

Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн “тухай хуулийн” гэсний дараа “21 дүгээр зүйлийн 21.3.1 дэх заалтын “нэг дэх” гэснийг “нэг, хоёр дахь” гэж, 21.3.2 дахь заалтын “хоёр” гэснийг “гурав” гэж” гэж, мөн зүйлийн “24 дүгээр зүйлийн” гэсний өмнө “23 дугаар зүйлийн гарчгийн, 23.1 дэх хэсгийн “нэг дэх” гэснийг “нэг, хоёр дахь” гэж, мөн зүйлийн 23.3 дахь хэсгийн “нэг дэх” гэснийг “хоёр дахь” гэж, 24 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 24.1 дэх хэсгийн “Хоёр” гэснийг “Гурав” гэж,” гэж, мөн зүйлийн ““Тамгын газрын” гэсний өмнө “25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийн” гэж нэмж, мөн зүйлийн “Энэ хуулийн 22.1.2, 22.1.3-т заасан асуудлаар” гэснийг, мөн зүйлийн “энэ хуулийн 22.1-д заасан асуудлаар” гэснийг, төслийн 3 дугаар зүйлийг хасах.

Санал хураалт.

11 гишүүн дэмжиж 64.7 хувиар санал дэмжигдлээ.

2 дахь санал.

Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн “тухай хуулийн” гэсний дараа “14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтын “Ерөнхий сайдын сар бүрийн” гэснийг “Улсын Их Хурлын асуулгын хүрээнд хийх” гэж” гэж нэмэх.

Санал хураалт.

11 гишүүн дэмжиж 64.7 хувиар санал дэмжигдлээ.

Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.2-т заасны дагуу хураалгах санал аа.

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Санал хураалт.

17 гишүүнээс 10 гишүүн дэмжиж 58.8 хувиар санал дэмжигдлээ.

Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2-т заасны дагуу хураалгана.

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Санал хураалт.

17 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 64.7 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн чуулганы хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар дарга танилцуулна аа.

Сая хураасан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

11.26 цаг

Дараагийн асуудалдаа оръё. 4 дэх асуудал.

Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд байдаг Халдашгүй байдлын дэд хорооны даргыг сонгох чөлөөлөх тухай асуудалд оръё.

Улсын Их Хурлын гишүүний Халдашгүй байдлын дэд хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргад нэр дэвшигчийг танилцуулна.

Миний бие Халдашгүй байдлын дэд хорооны даргаар нэг жил ажилласан. Ингээд Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад сонгогдсон учраас Халдашгүй байдлын дэд хорооны даргаас чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн байгаа.

Ингээд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргад нэр дэвшигчийг танилцуулна.

Танилцуулгыг Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга Бат-Эрдэнэ дарга танилцуулна.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргад Цэрэнпилийн Даваасүрэнг нэр дэвшүүлж байна аа.

Даваасүрэн нь 1983 онд Хөвсгөл аймгийн Мөрөн хотын 10 жилийн 1 дүгээр дунд сургууль төгссөн, 1989 онд ЗХУ-ын Харьков хотын Политехникийн Дээд сургууль, 1994 онд Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтэд Бизнесийн

удирдлагын менежер мэргэжлээр, 1998 онд Япон улсын Сайтомагийн их сургуульд эдийн засагч мэргэжлээр тус тус төгссөн.

1989-өөс 1982 онд Төвийн эрчим хүчний системд автоматик инженер, 1995-1999 онд Сангийн яамны Валютын харилцааны газарт мэргэжилтэн, 1999-өөс 2000 онд Сангийн яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээний газрын дарга, 1999 онд Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын Гадаад харилцааны хэлтсийн дарга, 2000-2005 онд Санхүү, эдийн засгийн яамны Төрийн сангийн газрын дарга, 2005-аас 2008 онд БСШУЯ-ны Санхүү эдийн Засгийн газрын дарга, 2005 онд Монгол Улсын Шадар сайдын эдийн засгийн зөвлөх, 2008-2012 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2009-2010 онд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга 2012-2016 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн 2012-2014 онд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, 2016-2020 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн 2017-2020 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайд, 2020-2024 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн 2023-2024 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны даргаар тус тус ажиллаж байсан. Монгол Улсын Их Хурлын гишүүн байна аа.

Ингээд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргад хэлэлцүүлж өгнө үү гэсэн саналыг өгч байна аа.

Ц.Сандаг-Очир: Бат-Эрдэнэ даргад баярлалаа.

Дэд хорооны даргад нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүн байна уу?

Тэмүүжин гишүүнээр тасаллаа. Даваасүрэн нэр дэвшигчийг дуудаарай.

Шижир гишүүн асуултаа асууя.

Ө.Шижир: Танилцуулга уншсан Бат-Эрдэнэ гишүүнээс асууя. Сая та танилцуулга уншихдаа Төсвийн байнгын хорооны дарга байсан гэж уншсан. 2024 оноос хойш гээд. Тэгээд одоогоор Төсвийн байнгын хорооны даргаасаа чөлөөлөгдөөгүй байгаа, яг одоогоор.

Тэгэхээр сая та байсан гээд уншихлаа.

Тэгээд 2 дугаарт бас Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүн биш хүн байгаа шүү дээ. Тэгэхээр бас тэр болдог уу?

Би нэг ийм л 2 асуулт асуух гэсэн юм.

Шижир гишүүний асуултад хариулъя.

Улсын Их Хурлын тухай хуулийн 27.7-д Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороодоос бусад дэд хорооны бүрэлдэхүүнд зөвхөн харьяалах Байнгын хорооны гишүүд орох бөгөөд Дэд хорооны бүрэлдэхүүн нь тухайн Байнгын хорооны гишүүдийн 2-ны 1-ээс илүү байна гэсэн байдаг.

27.8-д Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо Улсын Их хуралд хамгийн олон удаа сонгогдсон 9 гишүүнээс бүрдэх бөгөөд бүрэлдэхүүн

цөөнхийн төлөө төлөөс оруулна. Гишүүдийн сонгогдсон тоо адил байгаа тохиолдолд тэдгээрийн харьяалагдах нам эвслийн бүлгийн саналыг баримтална гэж байна.

Даваасүрэн гишүүн Төсвийн байнгын хорооны даргаас чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн байгаа. Төсвийн байнгын хороо өнөөдөр хуралдаж үндсэндээ бас чөлөөлөх асуудлыг нь хийгдэх юм байна лээ.

Ингээд Улсын Их Хурал 5 удаа сонгогдсон гэдгээр нь Халдашгүй байдлын дэд хорооны даргаар томилох асуудлыг МАН-ын бүлгээс оруулж танилцуулж байгаа юм байна гэдгийг бас хэлчихье ээ.

Ингээд нэр дэвшигчээс асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирыг Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргаас чөлөөлж Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэнг тус дэд хорооны даргаар сонгохыг дэмжье гэсэн.

Томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт гишүүдээ.

Дэд хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай байнгын хорооны тогтоол

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.10, 27.11 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг санал хураалтын дүнг үндэслэн ТББХ-оос тогтоох нь:

1.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэнг сонгосугай

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирыг Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Уг нь эсрэгээрээ юм байна. Намайг энэ тогтоолын төслийг эхлээд байрыг нь солиорой. Эхлээд Сандаг-Очирыг чөлөөлсүгэй тэгээд, сонгосугай Даваасүрэнг.

Тогтоолын төслийн 1, 2 дугаар зүйлээ өөрчил. Байрлалыг нь солиорой.

Ингээд уншсан байнгын хорооны тогтоолын төслийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт гишүүд ээ.

17 гишүүнээс 10 гишүүн дэмжиж 58.8 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргыг сонгох чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

ТББХ-ны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье ээ. Хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

11.25 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА